

Огноо 2021.04.07

№ 21/01

Улаанбаатар

**КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТҮҮНД
ХИЙГДСЭН ХАРААТ БУС АУДИТЫН
ДҮГНЭЛТИЙГ БАТЛАХ ТУХАЙ**

Фронтьер лэнд групп хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 04-р сарын 07-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын 21/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн хараат бус аудитын байгууллагаар хийлгэсэн аудитын тайлан, дүгнэлтийг зөвшөөрсүгэй.


ХУРЛЫН ДАРГА
Д. БАТСАЙХАН

Огноо 2021.04.07

№ 21/02

Улаанбаатар

**КОМПАНИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 1 дэх хэсгийн заалт, 9 дэх заалтийг үндэслэн Фронттиер лэнд групп хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 04-р сарын 07-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын 21/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Фронттиер лэнд групп ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-аас өгсөн дүгнэлтийг дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

 Д. БАТСАЙХАН

Огноо 2021.04.07

№ 21/03

Улаанбаатар

**КОМПАНИ ӨӨРИЙН ХУВЬЦААГАА
ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 49, 62, 88, 89-р зүйлүүд, 2021 оны 04-р сарын 07-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын 21/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

2. Компанийн хувьцаа эзэмшигчийн гаргаж буй санал хүсэлтийн дагуу хувьцааг эргүүлэн худалдан авахыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг Гүйцэтгэх Удирдлагад даалгасугай.
3. Эргүүлэн худалдан авах нэгж хувьцааны үнийг 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдрөөс өмнөх сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханш 385 /гурван зуун наян таван/ төгрөгөөр тогтоосугай.
4. Хувьцаа худалдан авах гэрээ байгуулж, худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал О. Амартүвшинд тус тус үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д. БАТСАЙХАН

Огноо 2021.04.07

№ 21/04

Улаанбаатар

ШААРДАХ ЭРХ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 53, 54 дүгээр зүйлүүд, 2021 оны 04 сарын 07–ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын 21/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Энэхүү хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцоогүй эсвэл хурлаас гаргасан шийдвэртэй санал нийлэхгүй байгаа хувьцаа эзэмшигчид Компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасны дагуу компанид хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг шаардах эрх үүссэн гэдгийг хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.
2. Хувьцаагаа эргүүлэн Компанид зарах хүсэлтэй хувьцаа эзэмшигчдийн хувьцааг хууль тогтоомжийн дагуу хувьцаа эргүүлэн авах журмыг боловсруулан хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалан ажиллахыг Гүйцэтгэх Удирдлагад үүрэг болгосугай.
3. Төлөөлөн Удирдах Зөвлөд энэхүү ажиллагаанд хяналт тавьж ажилласугай.

ХУРЛЫН ДАРГА


Д. БАТСАЙХАН

Огноо 2021.04.07

№ 21/05

Улаанбаатар

ХАЛААСНЫ ХУВЬЦААГ
ЭРГЭЛТЭЭС ГАРГАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 49, 62, 88, 89-р зүйлүүд, 2021 оны 04-р сарын 07-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын 21/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн хувьцаа эзэмшигчийн гаргасан саналын дагуу нийт хувьцааны 33% хувь болох 4,497,462 ширхэг халаасны хувьцааг эргэлтээс гаргасугай.
2. Эргэлтээс гаргах үйл ажиллагааг компанийн тухай хууль болон СЗХ-ны журам, МХБ-ны журмын дагуу хэрэгжүүлэхийг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д. БАТСАЙХАН

Огноо 2021.04.07

№ 21/06

Улаанбаатар

**КОМПАНИЙН ХЭЛБЭР
ӨӨРЧЛӨХ ТУХАЙ**

Фронтнер лэнд групп ХК-ийн 2021 оны 04-р сарын 07-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын 21/02 дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Фронтнер лэнд групп ХК-ийг өөрчлөн байгуулах замаар Фронтнер лэнд групп ХХК болгон өөрчилсүгэй.
2. Фронтнер лэнд групп ХХК-ны өөрчлөн байгуулах ажлыг хэрэгжүүлэхийг ТУЗ-д үүрэг болгосугай.
3. Фронтнер лэнд групп ХХК болгон өөрчлөх төслийг боловсруулж ТУЗ-аар батлуулж хэрэгжүүлэхийг гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

 Д. БАТСАЙХАН

Огноо 2021.04.07

№ 21/07

Улаанбаатар

НООГДОЛ АШИГ
ХУВИАРИЛАХГҮЙ ТУХАЙ

Фронттиер лэнд групп ХК-ийн 2021 оны 04-р сарын 07-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын 21/02 дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Төлөөлөн удирдах зөвлөлөөс танилцуулсан ноогдол ашиг хувиарлахгүй тухай шийдвэрийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Д. БАТСАЙХАН

Огноо 2021.04.07

№ 21/08

Улаанбаатар

**ХӨРӨНГӨ ХУДАЛДАН
БОРЛУУЛАХ ТУХАЙ**

Фронтнер лэнд групп ХК-ийн 2021 оны 04-р сарын 07-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын 21/02 дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Тус компанийн охин компани болох Эрдэнэс Говь Ланд ХХК-ийн 2000м2 анх авч байсан зах зээлийн үнээс одоогийн үнэ зөрүүтэй байгааг харгалзан өнөөгийн зах зээлийн түргэн борлогдох үнээр борлуулахыг гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.
2. Орон сууц, үйлчилгээны зориулалт бүхий
 - a. Ү-2205053060 /44,1 мкв орон сууц/
 - b. Ү-2205012191/35 мкв үйлчилгээний зориулалттай/,
 - c. Ү-/үл хөдлөхийн гэрчилгээ гараагүй 57,72 мкв орон сууц /,
байруудыг борлуулахыг гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д. БАТСАЙХАН

Огноо 2021.4.7

№ 21/09

Улаанбаатар

**ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ
ХИЙХИЙГ ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ**

Фронтнер лэнд групп ХК-ийн 2021 оны 04-р сарын 07-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын 21/02 дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компани, үүсгэн байгуулагчдын хооронд байгуулсан Туул Сонгино Усны Нөөц Цогцолбор төслийг хэрэгжүүлэх гэрээг хэлэлцэх, сунгахийг гүйцэтгэх удирдлагад даалгасугай.
2. Хөрөнгө оруулалтын гэрээг сунгахыг гүйцэтгэх удирдлагад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА


Д. БАТСАЙХАН

Огноо 2021-4-7

№ 21/10

Улаанбаатар

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ЗАРДЛЫН ТӨСӨВ БАТЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.13 дахь заалт, 2021 оны 4-р сарын 07-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 21/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Фронтнер Лэнд Групп” ХК-ийн 2021 оны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны төсөв, гишүүдийн цалин, урамшуулалыг хавсралтын дагуу баталсугай.
2. Батлагдсан төсвийн дагуу ажиллахыг эрх бүхий албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д. БАТСАЙХАН

Огноо 2021-4-7

№ 21/11

Улаанбаатар

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ
БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.13 дахь заалт, 2021 оны 4-р сарын 07-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 21/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Фронтьер Лэнд Групп” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны төсвийг хавсралтын дагуу баталсугай.
2. Батлагдсан төсвийн дагуу ажиллахыг эрх бүхий албан тушаалтнуудад үүрэг болгосугай.



ХУРЛЫН ДАРГА

Д. БАТСАЙХАН

Огноо 2021-4-7

№ 21/12

Улаанбаатар

**КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ГИШҮҮДИЙГ СОНГОХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.7 дахь заалт, 2021 оны 4-р сарын 07-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 21/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий зургаан хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

Ердийн гишүүн

1. Б. Батпүрэв
2. Б. Наранцогт
3. Г. Алтаймаа
4. Г. Оюунболд
5. Д. Батсайхан
6. О. Амартүвшин

2. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий гурван хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.

Хараат бус гишүүн

1. Д. Үнэнбат
2. С. Батбилэг
3. Ц. Мөнхбаяр

ХУРЛЫН ДАРГА



Д. БАТСАЙХАН